

СОГТУУРУУЛАХ УНДААГААР ҮЙЛЧЛЭХ ЦАГИЙН ХЯЗГААРЫГ
ТОГТООСОН ШИЙДВЭР, ТҮҮНИЙ ҮР ДАГАВАРЫН
ТАЛААР ХЭСЭГЧИЛСЭН СУДАЛГАА

2018 оны 5 дугаар
сарын 25-ны өдөр

Улаанбаатар
хот

Нэг.Эрх зүйн зохицуулалтын талаар

УИХ-ын 2003 оны 48 дугаар тогтоолоор “Архидан согтуурахаас сэргийлэх, хяналт тавих үндэсний хөтөлбөр”-ийг баталсан. Уг бодлогын баримт бичигт “Согтууруулах ундаа худалддаг, түүгээр үйлчилдэг цэгийн тоо хэт нэмэгдсэн төдийгүй баар, цэнгээний газруудын үйлчилгээний цагийн хуваарийг 1-3 цагаар хэтрүүлэх зөрчил гарсаар байгааг онцолсон”. Мөн согтууруулах ундааг худалдах, түүгээр үйлчлэх цэгийн байршил, тархалт, худалдах, үйлчлэх цаг хугацааны талаар зохицуулалт хийж, цэг салбарын тоог цөөрүүлэх, согтууруулах ундаагаар үйлчлэхгүй, худалдахгүй өдөр, цагтай болох зорилтыг дэвшүүлсэн.

Хөтөлбөрийн зорилтуудыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2007 оны 71 дүгээр тогтоолоор согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих журмыг батлан шөнийн 00.00 цагт баар цэнгээний газрыг хаах, 2009 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн сар бүрийн 1-ний өдөр Нийслэлд архи согтууруулах ундаагаар үйлчлэхгүй байх зохицуулалтыг мөрдөж эхэлсэн. Улмаар Нийслэлийн Засаг даргын 2013 оны “Худалдаа, үйлчилгээний байгууллагуудын ажиллах цагийн хуваарийг батлах тухай” А/548 дугаар захирамжаар шөнийн 00.00 цаг хүртэл согтууруулах ундаагаар үйлчилж байсан.

Хууль тогтоомжоор шөнийн 00.00 цаг хүртэл согтууруулах ундаагаар үйлчлэх хязгаарыг тогтоосон боловч баар цэнгээний газрууд цаг хэтрүүлж ажилладаг байдал буурахгүй, түүнчлэн нутаг дэвсгэр, засаг, захиргааны нэгжүүд хүн амын тооноос хамаарч архи согтууруулах ундаагаар худалдах цэгийн зөвшөөрлийг тооцож олгохгүй явж ирснээс архидан согтуурах, түүнээс үүдэлтэй гэмт хэргийн тоон үзүүлэлт тогтмол өсчээ. Тухайлбал: Нийслэлийн хэмжээнд 2013 онд согтуугаар үйлдэгдсэн нийт 3465 гэмт хэргийн 1686 буюу 48.7 хувь нь, 2014 онд согтуугаар үйлдэгдсэн нийт 3462 гэмт хэргийн 1738 буюу 50.2 хувь нь 22.00-06.00 цагийн хооронд үйлдэгдсэн байдаг.

Хамгийн сүүлд Нийслэлийн Засаг Даргын 2015 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн А/609 дүгээр захирамжаар “Согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй үйлчилгээний газруудын үйл ажиллагаа явуулах цагийн хязгаарыг иргэдийн санал хүсэлтийг үндэслэн шөнийн 4 цаг хүртэл байхаар тогтоосон нь одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.

Хоёр.Нөхцөл байдлын талаар

Улаанбаатар хотын Захирагчийн албанаас энэ оны 5 дугаар сард “Нийслэлийн худалдаа, үйлчилгээний газруудын ажиллах цагийн хуваарийг шинэчлэх асуудлаар санал асуулга” явуулж байна. Санал асуулгын дүнг 5 дугаар сарын 25-ны байдлаар авч үзэхэд санал асуулгад оролцогчдын 53.2 хувь нь баар цэнгээний газрыг 00.00 цагт хаах саналыг гаргасан.

Цагдаагийн байгууллагын статистик мэдээгээр Нийслэлийн хэмжээнд 2018 оны эхний 4 сард согтуугаар үйлдэгдсэн нийт 1095 гэмт хэргийн 572 буюу 52.2 хувийг 22.00-06.00 цагийн хооронд үйлдсэн байна. Мөн шөнийн 04.00 цагаас хойш баар, цэнгээний газар, саун массаж, хүнсний дэлгүүр, цахим тоглоомын газрууд тогтмол цагийн хязгаарыг зөрчиж, цаг хэтрүүлснээс хоногт дунджаар танхайрсан, иргэдийн эрх чөлөөнд халдсан 140-180 согтуугийн дуудлага, мэдээлэл бүртгэгдсэн.

2017 оны 12 дугаар сарын 19-ний өдрөөс хойш шөнийн цагаар цаг хэтрүүлж, хууль тогтоомж зөрчин үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавих зорилгоор “Эмзэг цэг-Хяналт шалгалт” арга хэмжээг Нийслэлийн хэмжээнд зохион байгуулж ажиллахад цаг хэтрүүлэн ажилласан баар 17, караоке 18, ресторан 1, паб 2, хүнсний дэлгүүр 14 бүртгэгдсэн.

Нийслэлийн хэмжээнд архи, согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөлтэй худалдааны 3933, үйлчилгээний 2539, нийт 6472 аж ахуйн нэгж байгууллага бүртгэгдсэнийг нийслэл хотын суурин хүн ам болох 1.417.396 хүнд ногдох¹ байдлаар авч үзэхэд 100 000 хүн ам тутамд 277.4 согтууруулах ундаа худалдах газар, 179.1 согтууруулах ундаагаар үйлчлэх баар цэнгээний газар тус тус ногдож байна. Үүнийг дүүргүүдээр харуулбал:

д/д	Дүүргүүд	Тусгай зөвшөөрөлтэй худалдааны байгууллага	Тусгай зөвшөөрөлтэй үйлчилгээний байгууллага	Нийт аж ахуйн нэгж байгууллага
1	Баянгол	579	705	1284
2	Баянзүрх	1023	418	1441
3	Сонгинохайрхан	922	288	1210
4	Сүхбаатар	362	495	857
5	Хан-Уул	417	217	634
6	Чингэлтэй	433	335	768
7	Багануур	38	20	58
8	Налайх	151	58	209
9	Багахангай	8	3	11
	Бүгд	3933	2539	6472

Нийслэлийн хэмжээнд энэ оны эхний 4 сард 10815 гэмт хэрэг бүртгэгдсэний 1095 буюу 10.1 хувийг согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг эзэлсэн нь урд оны мөн үеийнхээс 207 буюу 23.3 хувиар өссөн дүн мэдээтэй байна.

Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийг төрлөөр нь өмнөх оны мөн үетэй харьцуулж үзвэл:

№	Гэмт хэргийн төрөл	Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг			
		2017 оны эхний 4 сар	2018 оны эхний 4 сар	Нэгж	Хувь
1	Хүнийг алах	24	16	-8	-33.3
2	Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх	6	15	9	150.0
3	Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах	479	673	194	40.5
4	Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх		33	33	
5	Хүчиндэх	22	43	21	95.5
6	Хулгайлах	79	112	33	41.8
7	Халаасны хулгай	2	5	3	150.0
8	Дээрэмдэх	28	47	19	67.9
9	Залилах	2	9	7	350.0
10	АТХХАБА журам зөрчих	21	23	2	9.5
11	Бусад	225	119	-106	-47.1

Харин нийслэлд согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийг цагаар нь авч үзвэл 52.8 хувь нь шөнийн 22.00-06.00 цагийн хооронд бүртгэгджээ. Үүнд:

Огноо/цаг	Цаг, хугацаа							
	06-16 цаг	Хувь	14-21 цаг	Хувь	19-24 цаг	Хувь	22-06 цаг	Хувь
2016 он	301	11.6	430	16.6	470	18.2	1383	53.5
2017 он	267	10.9	455	18.6	430	17.6	1290	52.8
2017 оны эхний 4 сар	81	9.1	164	18.5	174	19.6	469	52.8
2018 оны эхний 4 сар	145	13.2	200	18.3	178	16.3	572	52.2

¹ <http://www.ubstat.mn/>

Нийслэлийн хэмжээнд согтуугаар үйлдэгдсэн зөрчлийг дүүргүүд дэх цагдаагийн хэлтэс тус бүрээр нь ангилж хүснэгтээр харуулбал:

д/д	Дүүргүүд дэх цагдаагийн хэлтэс	Согтуугаар үйлдэгдсэн зөрчлийн тоо	Хувь
1	Баянзүрх	290	26.4 хувь
2	Сонгинохайрхан	225	20.5 хувь
3	Сүхбаатар	113	10.3 хувь
4	Баянгол	147	13.4 хувь
5	Чингэлтэй	110	10.0 хувь
6	Хан-Уул	119	10.8 хувь
7	Налайх	36	3.2 хувь
8	Багануур	49	4.4 хувь
9	Багахангай	6	0.5 хувь


Нийт согтуугаар үйлдэгдсэн зөрчлийн 290 буюу 26.4 хувь нь Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн нэг, хоёр, гуравдугаар, 225 буюу 20.5 хувь нь Сонгинохайрхан дүүргийн нэг, хоёр, гуравдугаар хэлтсүүдийн хүн ам нягтаршсан, амьдралын түвшин доогуур иргэд бүхий нутаг дэвсгэрт гарсан байна. Нийслэлийн хэмжээнд согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийг дүүргүүд дэх цагдаагийн хэлтэс тус бүрээр нь хүснэгтээр үзүүлбэл:

д/д	Дүүргүүд дэх цагдаагийн хэлтэс	Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн тоо	Хувь
1	Баянзүрх	296	26.3 хувь
2	Сонгинохайрхан	225	20.6 хувь
3	Сүхбаатар	113	10.3 хувь
4	Баянгол	147	13.5 хувь
5	Чингэлтэй	110	10.0 хувь
6	Хан-Уул	119	10.9 хувь
7	Налайх	36	3.6 хувь
8	Багануур	49	4.5 хувь
9	Багахангай	6	0.5 хувь

Нийслэлийн хэмжээнд согтуугаар үйлдсэн гэмт хэргийг үйлдэгдсэн газраар авч үзвэл:

д/д	Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг	Хувь
1	Гэр орон сууцанд	478 буюу 43.6 хувь
2	Гудамж талбайд	272 буюу 24.8 хувь
3	Олон нийтийн газар	225 буюу 20.5 хувь
4	Аж ахуйн нэгж	43 буюу 3.9 хувь
5	Бусад газар	41 буюу 3.7 хувь
6	Авто замд	14 буюу 1.2 хувь
7	Нийтийн тээвэрт	3 буюу 0.2 хувь
8	Төрийн байгууллагад	6 буюу 0.6 хувь
9	Төрийн бус байгууллагад	3 буюу 0.2 хувь

Нийслэлийн хэмжээнд согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн гаргийг авч үзэхэд долоо хоногийн ажлын болон амралтын өдрүүд ойролцоо хувьтай байна. Үүнд:



Дээрх тоон мэдээлэл, судалгаанаас дүгнэн үзэхэд дараах шийдвэр, үйл ажиллагааг явуулах хэрэгцээ шаардлагатай болох нь харагдаж байна. Үүнд:

1. 2017 онд Засгийн газрын 11-11, Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвөөр уламжлагдан 16 гомдол, мэдээлэл иргэдээс ирсний 9 нь буюу 56 хувь нь шөнийн цагаар архи, согтууруулах ундаа зарж, үйлчилж байна, иргэдийн амгалан тайван байдал алдагдаж байгаа тухай, 2016 онд 63 гомдол хүсэлт ирсний 65 хувь нь “Шөнийн цагаар ажиллаж байгаа цэнгээний газрууд дуу чимээ ихтэй байна. Унтаж амарч чадахгүй байна, дуу чимээний хязгаарлалт гэж байна уу, иргэдийн тайван байдлыг хангаж өгөөч” гэх гомдлууд иржээ.

Нийслэлийн хэмжээнд 2016 онд согтуугаар үйлдэгдсэн нийт 2584 гэмт хэргийн 1383 буюу 53.5 хувь нь, 2017 онд согтуугаар үйлдэгдсэн нийт 2442 гэмт хэргийн 1290 буюу 52.8 хувь нь, 2018 оны эхний 4 сард согтуугаар үйлдэгдсэн нийт 1095 гэмт хэргийн 572 буюу 52.2 хувь нь 22.00-06.00 цагийн хооронд тус тус үйлдэгдсэн байна. Эдгээрээс үзэхэд согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх худалдаа, үйлчилгээний газрын цагийн хязгаарыг нутаг дэвсгэрийн онцлог, хүн амын нягтаршил, гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдлыг харгалзан нийслэл хотод 08.00-23.00 цаг байхаар шинэчлэн тогтоолгох шаардлагатай байна.

2. Зөрчлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, согтууруулах ундаагаар үйлчилсэн болон үйлчилгээний байгууллагын цагийн хязгаарт ямар байгууллага хяналт тавих, цагийн хязгаар зөрчсөн тохиолдолд аль байгууллага хариуцлага хүлээлгэхийг тодорхой зааж, ногдуулах хариуцлагыг чангатгах нь зүйтэй байна. Мөн гадаадын зарим орны жишгээр 7 хоногийн амралтын аль нэг өдрийг архигүй өдөр болгох нь иргэдийн аюулгүй, амар тайван амьдрахад болон гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдалд эерэгээр нөлөөлөх сайн талтай.

ДҮН ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГААНЫ ХЭЛТЭС